

үйлчилгээний төлбөрийг  
“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төрийн банкны 241801465307 тоот дансанд тушааж, тус компанийн төв байрны 106 тоот өрөөнөөс техникийн нөхцөлөө авна.

- Иргэн, хуулийн этгээд нь батлагдсан техникийн нөхцөлийн дагуу өөрийн шинээр барих объектын зураг төсөв, угсралт, хэмжилт туршилтын ажлыг бусад эрчим, хүчний барилга байгууламж барих эрх бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниар гүйцэтгүүлж болно.
- Иргэн, хуулийн этгээд нь дэд станц, шугам тоноглолыг сүлжээнд холбоход бүрдүүлсэн гүйцэтгэлийн баримт бичгийг архив, мэдээллийн санд бүртгүүлээд ашиглалтад оруулах комисс ажиллуулан хүчдэлд залгаж болох тухай дүгнэлт гаргуулсан байна.
- Байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шуурхай ажиллагааны нэр, дугаар олгон иргэн, хуулийн этгээдтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан мэдээллийн санд бүртгэн сүлжээнд залгах зөвшөөрөл олгоно.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн объектыг баталгаажсан залгах зөвшөөрөл, шуурхай ажиллагааны болон ашиглалт үйлчилгээний гэрээг үндэслэн хүчдэлд залгана.




УЛААНБААТАР ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК

Техникийн нөхцөл авах, сүлжээнд шинээр холбогдох иргэн, хуулийн этгээдэд зориулсан зөвлөмж

Техникийн нөхцөл олгох цахим үйлчилгээ

<http://new.tog.mn>



Хаяг: УБ хот, ХУД, Чингисийн өргөн чөлөө,  
УБЦТС ТӨХК-ийн төв байр 106 тоот өрөө  
Утас: 341892. 342420 (194)  
Технологийн холболтын алба

1. Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох, техникийн нөхцөлд заасан чадлыг нэмэгдүүлэх, бууруулах, өөрчлөлт оруулах шаардлага гарсан тухай бүрт техникийн нөхцөл авна.

2. Цахилгаан түгээх сүлжээнд объектоо холбуулахыг хүссэн иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн <http://new.tog.mn> цахим хуудсаар дамжуулан эсвэл харьяа хүсэлт хүлээн авах цэгүүдэд өөрийн биеэр очиж дүүрэг, хороо, цахилгаан хэрэглээний чадал, зориулалт, газарзүйн байршил зэрэг мэдээллийг өгнө.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сүлжээний мэдээлэлд үндэслэн иргэн, хуулийн этгээдийн объектыг цахилгаан түгээх сүлжээнд холбоход техникийн боломжтой эсэхийг судалж, шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагчийн хамт сүлжээнд холбох объектын байршилд очиж техникийн боломж, хүчин чадал, байршил, хамгаалалтын зурвас зөрчсөн эсэхийг тодруулах ажлыг хийнэ.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн нөхцөл олгохдоо уг объектын хүчин чадлын одоогийн хэмжээ, цаашдын өсөлт, тэжээл авах шугам тоноглолын ачаалал, тухайн бүсийн өсөн нэмэгдэх хэрэглээ, хэтийн төлөвтэй уялдуулан шийднэ.

5. Техникийн нөхцөлийг олгохдоо уг барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх тухай удирдах дээд байгууллага болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэр, хангагчид гаргасан хүсэлт, эрх бүхий байгууллагаас олгосон газрын гэрчилгээг үндэслэнэ.

6. Иргэн, хуулийн этгээд нь дараах үндсэн баримт бичиг (эх хувь эсвэл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар хувь)-ийг бүрдүүлнэ.

- Өргөдөл буюу албан хүсэлт;
- Иргэний үнэмлэх;

- Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Газрын гэрчилгээ (өмчлөх, ашиглах, эзэмших);
- Газрын кадастрын зураг;
- Батлагдсан маягтын дагуу бөглөсөн тодруулах хуудас.

7. Иргэн, хуулийн этгээд нь дээр дурдсан үндсэн бичиг баримтаас гадна хүсэлтийн онцлогоос хамаарч дараах материалыг бэлдсэн байх шаардлагатай.

- Хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан барилга барих тохиолдолд архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан “Ерөнхий төлөвлөгөө” (эх хувь эсвэл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар хувь);
- Олгогдсон техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах бол тухайн техникийн нөхцөлийн хуулбар;
- Техникийн нөхцөлийн нэр шилжүүлэх бол тухайн техникийн нөхцөл, газрын гэрчилгээ, кадастрын зураг, нэр шилжүүлэхэд үндэслэл болох баримт бичиг /худалдах, худалдан авсан гэрээ гэх мэт/;
- Цахилгаан түгээх сүлжээг зөөж байршил өөрчлөхөд түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс дэвсгэр зурагт тодруулга хийсэн тодорхойлолт, харьяа орон нутгийн ерөнхий төлөвлөгөө эрхэлсэн газрын албан хүсэлт.

8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор судалгааг хийж иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгох боломжтой эсэх хариуг мэдэгдэнэ.

9. Техникийн нөхцөл батлагдсан тохиолдолд хүсэлт гаргахад бүртгүүлсэн гар утас руу техникийн нөхцөл батлагдсан тухай болон төлөх төлбөрийн мөнгөн дүнгийн мэдээллийг мессэжээр илгээнэ. Техникийн нөхцөлийн